



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын сэдэв: “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн”

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоолын дагуу Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу гүйцэтгэв.

**ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ,
ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮНГИЙН ТАЛААР ИРГЭД, ОЛОН НИЙТЭД ХҮРЭХ
МЭДЭЭЛЭЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

Аудитын тайланг хүргүүлсэн: Дархан-Уул аймгийн ИТХ, Засаг дарга, Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумын Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар, “Орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ, “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ

ДАРХАН-УУЛ АЙМАГ

2024 оны 07 дугаар сар

Аудитын зорилго, зорилтууд:

ОНХС-ийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх;

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад ОНХС-ийн бүрдүүлэлт, зарцуулалт, хяналт тавих чиг үүрэг бүхий дараах байгууллагууд хамрагдсан.

- Аймаг, сумдын ЗДТГ-ын ХБТХОХ, СТСХ, Төсвийн тухай хууль холбогдох журамд заасны дагуу төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах харилцааг зохицуулах чиг үүрэгтэй
- Аймаг, сумдын ЗДТГ нь-ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу Захиалагчийг төлөөлөн худалдан авах ажиллагааг зохион байгуулах чиг үүрэгтэй
- Аймгийн ИТХ- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.2.2 дахь хэсэг, “ДХББЗГ” ОНӨААТҮГ – Хуулийн дагуу захиалагч байгууллагатай байгуулсан гэрээний дагуу хяналтын үүргийг гүйцэтгэх чиг үүрэгтэй
- Тендерт шалгарч, ажил гүйцэтгэсэн 235 иргэн, аж ахуйн нэгж байгууллага хамрагдсан болно.

БҮЛЭГ 1 ОНХС-ИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ХУУЛЬД ЗААСАН ЭХ ҮҮСВЭРЭЭС БҮРЭН БҮРДҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨӨГҮЙ БОЛОВЧ АЙМГИЙН ОНХС-Д ОЛГОХ ОРЛОГЫГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХУВААРИЛЖ ОЛГОСОН БАЙНА.

1.1.1 ОНХНС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн байна

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар Дархан-Уул аймагт улсын төсвөөс олгох ОНХНС-ын орлогын шилжүүлгийг 10,881.5 сая төгрөгөөр баталсан ба 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 2,661.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 13,473.1 сая төгрөгөөр баталжээ.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 53 дугаар тогтоолоор баталсан төсвийн тодотголоор орон нутгийн хөгжлийн сангийн төсвийг ОНХНС-гаас 12,684.8 сая төгрөг, Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт дэмжих, ОНХС-ийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, сайн гүйцэтгэлийг урамшуулах замаар “Тогтвортой амьжиргаа-3” төслийн урамшууллаас 788.3 сая төгрөг, малын тоо, толгойн албан татвараас 364.5 сая төгрөг, сангийн өмнөх оны үлдэгдлээс 3,648.4 сая төгрөг, нийт 17,486.0 сая төгрөгийн санхүүжилтээр бүрдүүлэхээр баталсан байна.

1.1.2 ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хууль, журмаар баталсан аргачлалын дагуу хуваарилж олгосон байна

ОНХНС болон улсын төсвийн эх үүсвэрээс Дархан-Уул аймагт хуваарилсан хөрөнгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2, 59.3, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “ОНХНС болон ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу хуваарилжээ.

1.1.3 Аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийг ажлын гүйцэтгэлээр нь олгосон байна.

Аймгийн Засаг дарга 2022 онд 01-А/375 тоот захирамжаар баталсан ОНХС-ийн 2023 оны төсвийн хуваарийг 2023 оны 01-А/198 тоот захирамжаар 137.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталж, 1,348.7 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон байна

1.1.4 Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө бусад эх үүсвэрийг судалж, төлөвлөөгүй

ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө ОНХС-аас олгох орлогын шилжүүлгээс өөр эх үүсвэрийг судалж, зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр, тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламжийг төлөвлөөгүй байна.

1.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар аваагүй байна

Орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд ОНХС-ийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог хангах зайлшгүй шаардлагатай.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр тухайн онд шинээр 5,532.6 сая төгрөгийн 94 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталжээ.

Аймгийн хэмжээнд нийт 9,054 иргэнээс санал авсныг хөдөлмөрийн насны хүн амын тоотой харьцуулахад 12.9 хувийг эзэлж байна.

Энэ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар авахгүй байгаа нь харагдаж байна.

1.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан байна

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний 53 хувь нь иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологийг хөгжүүлэхэд, 36 хувь нь нийтийн эзэмшлийн зам талбай тохижилт, авто замын засвар, шинэчлэлт, гэрэлтүүлэг, ногоон байгууламж, дэд бүтэц шинээр бий болгоход чиглэгджээ.

Эдгээр нь Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилтод тусгасан хүний хөгжил, амьдралын чанар ба дундаж давхарга, дэд бүтэц, ногоон хөгжил зэрэг үндсэн чиглэлтэй уялдаж, мөн аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн эрүүл мэнд, биеийн тамир, спорт, боловсрол, зам, тээвэр, байгаль орчин, зэрэг аймгийн хөгжлийн бодлогын үндсэн чиглэл болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан төлөвлөжээ.

БҮЛЭГ 2 ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ЖУРМЫН ДАГУУ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА

2.1.1. Зохион байгуулсан худалдан авах ажиллагааны 15.7 хувь нь ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчсөн байна

Аймаг, сумдын ТЕЗ нь Сангийн сайдын 2021 оны 86 тоот тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.1¹, 3.4.1²-т заасны дагуу ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан байна.

¹ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хууль, журмын дагуу боловсруулан бэлтгэж тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах;

² ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хууль, журмын дагуу боловсруулан бэлтгэж тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах;

Тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 13,513.6 сая төгрөгийн 222 төсөл, арга хэмжээг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7.1³-д заасны дагуу сонгон шалгаруулах арга хэмжээг зохион байгуулж нээлттэй тендер шалгаруулалтаар 10,095.9 сая төгрөгийн 33 төсөл, арга хэмжээ, харьцуулалтын аргаар 1,130.3 сая төгрөгийн 18 төсөл, арга хэмжээ, 1,827.4 сая төгрөгийн 172 төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулжээ.

Барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг улирлын шинж чанартай гүйцэтгэх 1,155.9 сая төгрөгийн 5 ажлыг төсвийн жилийн 3, 4 дүгээр улиралд зохион байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.8⁴ дэх заалттай нийцэхгүй байна.

Мөн тендерийн үнэлгээний хороотой холбоотой 6 зөрчил илэрсэнд Шарын гол сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу зохион байгуулаагүй үнэлгээний хорооны даргад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгч, Сангийн сайдын 2021 оны 86 тоот тушаалаар батлагдсан журмын 3.3.7⁵, 3.4.4⁶-д заасныг мөрдөж ажиллах талаар сумдын Засаг дарга нарт зөвлөмж хүргүүлсэн.

2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 97.6 хувь нь төлөвлөсөн зорилтот түвшин, үр дүнд хүрсэн байна.

Бүрэн хэрэгжүүлсэн 208 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, зорилтот түвшин 97.6 хувийн гүйцэтгэлтэй, бүрэн болон дутуу хэрэгжсэн гүйцэтгэлтэй 230 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн зорилтот түвшинтэй харьцуулахад 85.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр сум, орон нутгийн хөгжилд үр дүнгээ өгөх ТАХ-г хэрэгжүүлсэн байна

ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд нийт 235 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ хэрэгжүүлэхэд 13,217.8 сая төгрөг зарцуулжээ. Үүнээс 90.6 хувь буюу 12,759.1 сая төгрөгийг авто замын засвар шинэчлэлт, орчны тохижилт, ногоон байгууламж, гэрэлтүүлэг, дэд бүтэц татах, машин тоног төхөөрөмж, эмнэлгийн тоног төхөөрөмж, усан хангамжийн эх үүсвэрийг хамгаалах, төрийн үйлчилгээний “Хурдан систем”-ийг нэвтрүүлэх зэрэг орон нутгийн хөгжилд бодитой үр дүн үзүүлэх төсөл, арга хэмжээнд зарцуулсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр тухайн бүс нутгийн иргэдийн саналд үндэслэн иргэдийн эрүүл мэнд, амьдрах орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор орчин үеийн шинэ техник технологид суурилсан, цаг хугацаа хэмнэсэн, хүний хөдөлмөрийг хөнгөвчилсөн зэрэг САЙН ЖИШЭЭ 5 ТАХ-г санхүүжүүлсэн байна

2.3.1. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон ТАХ-ны 96.6 хувийг зориулалтын дагуу ашиглаж байна

Дархан-Уул аймгийн хэмжээнд 2023 онд ОНХС-ийн санхүүжилтээр 10,878.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 213 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж дуусаж ашиглалтад хүлээн авсан байна. Аудитаар дээрх ТАХ-ний үр дүнд бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллага бүрэн ашиглаж байгааг газар дээр нь үзэж шалгахад 2 ТАХ-ээс бусад нь зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаараа ашиглагдаж байна.

³ Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна;

⁴ барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх;

⁵ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг холбогдох хууль, аргачлал, журамд нийцүүлэн хийх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах хяналт тавих;

⁶ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг холбогдох хууль, аргачлал, журамд нийцүүлэн хийх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих;

2.3.2. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт зохистой байна.

Аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн үр дүнд бий болсон хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр ашиглагч байгууллагуудад эзэмшүүлсэн байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг тулган шалгахад 2 зөрчил илэрч холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлсэн

БҮЛЭГ 3 ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БӨГӨӨД ҮР ДҮНГ БҮРЭН ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА

3.1.1 Аймгийн ИТХ, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт шалгалт хийгээгүй байна

Дархан-уул аймаг дахь ТАГ-аас аймгийн ИТХ, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэлийн явцад хийсэн хяналт, шалгалтын тайланг ирүүлэх тухай 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 244, 245 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч аймгийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо тайлан ирүүлээгүй, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2022, 2023 онд хяналт, шалгалт хийгээгүй талаар хариу мэдэгдсэн.

3.1.2. “ДХББЗГ” ОНӨААТҮГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэлд хууль, журмын дагуу захиалагчийн хяналтыг хэрэгжүүлжээ

Аймгийн “ДХББЗГ” ОНӨААТҮГ нь Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.2⁷-д заасны дагуу захиалагчтай гэрээ байгуулж, гэрээнд заасан хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

3.1.3 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан ч алдаа, зөрчил давтагдан гарч байна

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 2022 онд гүйцэтгэсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд”-д хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар нийт 45.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 20.0 сая төгрөгийн 7 албан шаардлага, 25.5 сая төгрөгийн 13 зөвлөмж өгсөн байна. Биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 311 тоот албан бичгээр ирүүлсэн бөгөөд хэрэгжилтийг хянахад 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Гэсэн хэдий ч аудитаар өмнөх аудитаар илэрсэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, хөрөнгийн бүртгэл, худалдан авах ажиллагаа, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, засвар шинэчлэл, ашиглалттай холбоотой зөрчил давтагдан гарсан.

3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг журамд заасан хугацаанд тайлагнаагүй байна

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, сумын ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж Сангийн яамны ОНХС-ийн асуудал

⁷ “Барилга байгууламжийн хөрөнгө оруулагч захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай, эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллуулах бөгөөд Барилгын тухай хуулийн 37.2-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээр захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлж болно

хариуцсан нэгжид “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.9⁸-т заасан хугацаанд хүргүүлж ажиллаагүй байна.

3.2.2 Тайлант онд хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг тухайн жилдээ багтаан нягтлан бодох бүртгэлд тусгаагүйгээс төрийн өмч, хөрөнгө эзэнгүйдэх эрсдэлтэй байна

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд ашиглалтад орсон 8,658.7 сая төгрөгийн 172 ТАХ-ний үр дүнд бий болсон хөрөнгийн эзэмшигч, ашиглагчийг аймгийн Засаг даргын 2024 оны 01-А/99 дугаар захирамж, аймгийн ИТХ-ын 2023 оны 37, 2024 оны 08, 10, Шарын голын ИТХ-ын 2024 оны 51, Орхон сумын ИТХ-ын 2024 оны 02, Хонгор сумын 2023 оны 43 дугаар тогтоолоор баталснаар холбогдох байгууллагууд бүртгэлд тусгасан байна.

Харин холбогдох шийдвэр гарсан боловч 1,279.1 сая төгрөгийн 12 ТАХ-ний хүрээнд бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна.

3.2.3 Сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар УМС-д мэдээллийг бүрэн оруулаагүйгээс иргэд, олон нийт үнэн зөв, бодитой мэдээллээр хангагдахгүй байна

Сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын Арав⁹-т ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системд тухайн шатны ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ний мэдээллийг бүртгэхээр заасан байна.

Дархан-Уул аймаг 7,552.6 сая төгрөгийн 110 ТАХ, Орхон сум 722.1 сая төгрөгийн 13 ТАХ, нийт 8,274.7 сая төгрөгийн 123 ТАХ-г ОНХС хариуцсан мэргэжилтэн Удирдлагын мэдээллийн системд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг оруулаагүйгээс иргэд, олон нийтэд буруу ойлголтыг төрүүлэх, үнэн зөв, бодитой мэдээллээр хангагдахгүй байх үр дагавар үүсэж байна.

3.2.4 Шилэн дансны цахим системд 5,842.1 сая төгрөгийн 69 ТАХ-г хугацаа хоцроож мэдээлсэн, 218.7 сая төгрөгийн 11 ТАХ-ний зарцуулалтыг мэдээлээгүй байна.

Дархан-Уул аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны тухай хуулийн тогтоомжийн хэрэгжилтийг хангах, шилэн дансны цахим хуудасны 2023 оны хөтлөлт, мэдээлэл байршуулсан байдал, холбогдох баримт бичгийг бүрэн оруулсан байдалд хяналт тавьж, дүн шинжилгээ хийхэд Шилэн дансны цахим системд 5,842.1 сая төгрөгийн 69 ТАХ-г хугацаа хоцроож мэдээлсэн, 218.7 сая төгрөгийн 11 ТАХ-ний зарцуулалтыг мэдээлээгүй зөрчил илэрсэн

Шилэн дансны цахим системд нийт 6,060.8 сая төгрөгийн 80 ТАХ-г хугацаандаа мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1¹⁰, 6 дугаар зүйлийн 6.3.9¹¹, 6.9¹² дахь хэсэгт заасантай тус тус нийцээгүйгээс хэрэглэгчдэд буруу ойлголт төрүүлэх, үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээллийг олж авахгүй байх үр дагавар үүсэж байна.

Аудитаар нийт 16,125.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3.4 сая төгрөгийн төлбөрийн акт, чанаргүй хийгдсэн ажлыг дахин хийлгэх 27.8 сая төгрөгийн 2, хариуцлага тооцох 1, нийт 3 албан шаардлага хүргүүлэн, цаашид үйл ажиллагаанд мөрдөж ажиллах 16,094.3 сая төгрөгийн 22 зөвлөмж өгсөн.

⁸ Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгжид ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг тусгана.

⁹ ОНХС-ийн удирдлагын мэдээллийн систем

¹⁰ Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

¹¹ Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл

¹² Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт,